

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Е-Моние ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр live.ard.mn цахим хуудсаар дамжуулан 17:00 цагаас эхлэв.

Хурлыг нээж хурлын дарга Ч.Ганхуяг хувьцаа эзэмшигчдэд хандан мэнд дэвшүүлж, Тооллогын комиссын даргыг хурлын ирцийг танилцуулахаар урив.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх танилцуулав: Хувьцаа эзэмшигчид <https://live.ard.mn> 17:00 цагаас нэвтэрч эхэлсэн ирцийг 17:15 минут хүртэл бүртгэн авсан нийт 5 хувьцаа эзэмшигч хуралд оролцож 53,680 /Тавин гурван мянга зургаан зуун наян/ ширхэг буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 91.7 хувь хуралд оролцож байгааг хуралд оролцогсод болон хурлын даргад мэдээлэв. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцсон тухай хурлын дарга Ч.Ганхуягт мэдэгдэж, хурлыг нээв.

Хурлын дарга Ч.Ганхуяг хурлын дэг болон хуралд урилгаар оролцож буй ТУЗ-д нэр дэвшигчн;, Ард Менежмент ҮЦК ХХК-ийн удирдлагын алба, Тооллогын комисс Блүмсбюри Секьюритис ҮЦК ХХК тус тус танилцуулан Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Хэлэлцсэн нь №1:

2020 оны санхүүгийн болон үйл ажиллагааны жилийн тайлан батлах тухай;

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ч.Хандаа:

Ард Менежмент ҮЦК ХХК нь 2021 оны 2 дугаар сарын 9-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн багцын арилжаагаар Е-Моние ХК-ийн 52,925 ширхэг хувьцааг худалдан авч, тус компанийн нийт гаргасан хувьцааны 90.4 хувийн эзэмшигч болсон.

Е-Моние ХК нь санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компани юм. Уг компани нь 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй ба энэхүү компанийн худалдан авснаар үйл ажиллагааг тогтвортой явуулах цаашлаад үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллахаар төлөвлөж байгаа болно. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцийн хувьд 2020.12.30-ны байдлаар нийт гаргасан хувьцааны 56 орчим хувийг Бумбат Алтай ҮЦК, үлдсэн 40 гаруй хувийг бусад 127 хувьцаа эзэмшигч эзэмшиж байсан бол 2021.4.8-ны байдлаар нийт гаргасан хувьцааны 90.4 хувийг Ард менежмент, үлдсэн 9.6 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

Компанийн санхүүгийн тайланд Тэд Аудит ХХК нь аудит хийсэн ба аудитын дүгнэлтээр уг компани санхүүгийн тайлагналын хувьд бол олон улсын стандартад нийцсэн бүртгэл тайлан гаргасан байна гэж үзсэн. Санхүү байдлын тайланг харвал 2020 оны эцсээр 6.9 сая төгрөгийн хөрөнгөтэй. Үүнээс 5.5.сая төгрөгийн өр төлбөртэй 1.4 сая

төгрөгийн эздийн өмчтэй байсан. Харин орлогын тайлангийн хувьд үйл ажиллагаа явуулаагүй тул орлого зардал бүртгэгдээгүй байна.

Хэлэлцсэн нь №2:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох;

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ч.Хандаа:

Е-Моние ХК-ийн ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшиж байгаа төлөөллүүд маань уг компанийг цаашид өргөжүүлэн хөгжүүлж үйл ажиллагааны чиглэлийг илүү шинэчилж амжилттай төсөл болгохоор санаа нэгдэн нийлж байгаа төлөөллүүд цугласан гэж ойлгож байгаа. Хурлын дарга өөрийгөө товч танилцуулав. Мөн ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Б.Золбоо, Ө.Ашхүү, Г.Уянга, Ц.Бархас, Ч.Хандаа, Г.Оргил болон ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигч А.Ундрал, Б.Батзаяа, Х.Эрдэнэбаяр, Д.Ганзориг нар өөрсдийн боловсрол мэргэжил, ажлын туршлага зэргийг танилцуулав.

Хэлэлцсэн нь №3:

Компанийн хаягийг өөрчлөх;

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ч.Хандаа:

Е-Моние ХК нь Сэлэнгэ аймгийг Жавхлантад байрладаг үйл ажиллагаа явуулаагүй ХК. Харин Ард Менежмент компани нь тус компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхээр ажиллах тул хаягийг өөрчлөн Улаанбаатар хот, сүхбаатар дүүрэг ерөнхий сайд амарын гудамж дахь Ард Холдингсын байрны 2 давхарт гэсэн хаягаар өөрчлөх санал оруулж ирж байгаа.

Хэлэлцсэн нь №4:

Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай болон уг тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгох;

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ч.Хандаа:

Үйл ажиллагаатай холбоотойгоор зарласан хувьцааны дээд хязгаарыг тогтоож өгнө. Хувьцаа гаргах болгондоо хувьцаа эзэмшигчдийн хурал зарлахгүйгээр ТУЗ-д хуулийн хүрээнд зохих эрхүүдийг олгох харин гаргах хувьцааны дээд хязгаарыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоох санал оруулсан байгаа.

Танилцуулсан нь: Хурлын дарга Ч.Ганхуяг:

ТУЗ маань компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6 сая ширхэг энгийн хувьцаа нэмж гаргах. Тэгээд компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.4-т зааснаар бид нар ТУЗ-даа уг хувьцааг хуулинд заасан эрхийнхээ хүрээнд нэмж гаргах эздийг нь олж борлуулах тийм эрхийг өгч байгаан байна.

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ч.Хандаа:

Хувьцаа нэмж гаргахтай холбоотойгоор Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай болон уг тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгохоор санал оруулсан байгаа.

Хэлэлцсэн нь №5:

Компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байх тухай;

Танилцуулсан нь: Хурлын дарга Ч.Ганхуяг

Компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдах авах эрхээ хэрэгжүүлэхгүй байх санал оруулж байгаан байна.

Хэлэлцсэн нь №6:

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

Танилцуулсан нь: Гүйцэтгэх захирал Ч.Хандаа

2013 онд компанийн дүрэм бичигдсэн байсан тул сайжруулж өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа. Уг өөрчлөлтүүдэд компанийн зарласан хувьцааг 6 сая ширхэг хувьцаа гаргах, хаягийг өөрчлөх үйл ажиллагааг өргөжүүлэх саналуудыг шинэчилсэн дүрмийн найруулгад оруулъя. Тухайлбал Ицсанал оруулсан байгаа. Үүнтэй холбоотой дүрэмдээ холбогдох өөрчлөлтийг оруулах зөвшөөрлийг хувьцаа эзэмшигчдээсээ хүсэж байгаа тул та бүхэн дэмжин бидний ажилд тус болно гэж найдаж байна. Компанийн нэрийг өөрчлөх санал хувьцаа эзэмшигчдээс гарсан бөгөөд үүнийг дүрмийн шинэчилсэн найруулгад оруулах хүсэлтэй байна.

Хэлэлцэх асуудлуудыг танилцуулж дуусав.

Асуулт хариулт болон санал хураалт эхлэв.

Асуулт. Хувьцаа эзэмшигч: Батжаргал Ширэндэв

Хувьцаагаа хуваах уу?

Хариулт. Хурлын дарга Ч.Ганхуяг: Бид хувьцаагаа шинээр гаргах байдлаар хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлнэ.

Асуулт. Хувьцаа эзэмшигч: Дөлгөөнмөрөн Очирхуяг

Хувьцаагаа арилжаалж байгаа юм уу?

Хариулт. Хурлын дарга Ч.Ганхуяг: Ард Менежмент нь Хувьцаа арилжаалж эхлээгүй байгаа. Харин ХК гэдэг утгаараа МХБ-ээр арилжаалагддаг. Бид тухай бүрд нь мэдээллийг ил тодоор хүргээд явна.

Асуулт, хариулт дуусав.

Тооллогын комиссын дарга Г.Алтансүх Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтад 53,680 ширхэг хувьцаа буюу 91.7 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 1.1.Зөвшөөрсөн 53,680 ширхэг буюу 100 %.
 - 1.2.Татгалзсан 0 ширхэг 0 %.
 - 1.3.Түдгэлзсэн 0 ширхэг 0 % байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай санал хураалтад 53,680 ширхэг энгийн хувьцаа буюу 91.7 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо
---	--	-------------

Ердийн гишүүд

1	Галням Уянга	55,893
2	Чулуунбаатар Хандаа	57,268
3	Ганбат Оргил	55,588
4	Өнөрбаян Ашхүү	55,488
5	Цолмон Бархас	56,586

Хараат бус гишүүд

1	Хасаг Эрдэнэбаяр	50,288
2	Долингор Ганзориг	50,288
3	Батсайхан Батзаяа	50,288
4	Амарсайхан Ундрал	51,415

3. Компанийн хаягийн өөрчлөлтийг дүрэмд тусгах тухай санал хураалтад 53,680 ширхэг энгийн хувьцаа буюу 91.7 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 3.1.Зөвшөөрсөн 53,678 ширхэг буюу 100 %.
 - 3.2.Татгалзсан 0 ширхэг 0 %.
 - 3.3.Түдгэлзсэн 0 ширхэг 0 % байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй
4. Компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх тухай болон уг тоонд багтаан гаргах хувьцааны тоо, гаргах хэлбэр, гаргах хугацаа, нөхцлийг тогтоох эрхийг төлөөлөн удирдах зөвлөлд олгох санал хураалтад 53,680 ширхэг энгийн хувьцаа буюу 91.7 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 4.1.Зөвшөөрсөн 53,590 ширхэг буюу 99.83 %.
 - 4.2.Татгалзсан 88 ширхэг 0.16 %.
 - 4.3.Түдгэлзсэн 0 ширхэг 0 % байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

5. Компанийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжил худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байх тухай санал хураалтад 53,680 ширхэг энгийн хувьцаа буюу 91.7 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

5.1. Зөвшөөрсөн 20 ширхэг буюу 0.04 %.

5.2. Татгалзсан 53,658 ширхэг 99.96 %.

5.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0 % байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

6. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай санал хураалтад 53,680 ширхэг энгийн хувьцаа буюу 91.7 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

6.1. Зөвшөөрсөн 53,678 ширхэг буюу 100 %.

6.2. Татгалзсан 0 ширхэг 0 %.

6.3. Түдгэлзсэн 0 ширхэг 0 % байх тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн

6.4.63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хурлыг хаан хурлын дарга Ч.Ганхуяг болон ТУЗ-ийн гишүүд компанийн цаашдын ажил болон тавьсан зорилгын талаар товч танилцуулав.

Хурал 18 цаг 30 минутанд дуусав.

ХЯНАСАН:
ХУРЛЫН ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Ч.ГАНХУЯГ

Ч.ХАНДСҮРЭН